



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД**

2024-07-09 № 01/159

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дундговь аймгийн “Ардчилсан нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Дундговь аймгийн “Ардчилсан нам”-ын хорооны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (11 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 11 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

/Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

/Т.БАТСАЙХАН/

АХЛАХ АУДИТОР

/Ч.БЭРХСАЙХАН/



Дундговь аймгийн Ардчилсан Намын Хорооны  
2024 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн  
хурлаар хэлэлцэж батлав



**ДУНДГОВЬ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

---

АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ҮЗЭЛ САНААНД ТУЛГУУРЛАСАН НИЙГМИЙН  
ХӨГЖИЛД МОНГОЛЫН АРД ТҮМНИЙГ АНХЛАН УРИАЛАН ДУУДСАН УЛС ТӨРИЙН  
ХҮЧНҮҮДИЙН НЭГДЭЛ БОЛОХ АРДЧИЛСАН НАМ

## **ДУНДГОВЬ НУТГАА ИРГЭД НЬ ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, ЭРДЭМ МЭДЛЭГТЭЙ МОНГОЛ ӨРХ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ МАЛЧИН ТҮМНИЙ ХҮСЭЛТИЙН ДАГУУ**

- 15 сумын бүтээлч хөдөлмөрч иргэд “МАЛЧИН ТҮМЭН”, олон нийтийнхээ гаргасан санал санаачилга, хүсэл эрмэлзлэлийг сонсон харилцан ярилцаж ИРГЭДИЙНХЭЭ саналд тулгуурласан
- ард иргэдийнхээ оролцоотой хамтран хэрэгжүүлэх
- хөгжил дэвшлийнхээ залгамж чанарыг хадгалсан,
- орон нутгийнхаа язгуур эрх ашиг хөгжлийнхөө суурь чиг хандлагыг тодорхойлсон

2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАН ӨРГӨН БАРЬЖ БАЙНА.

Бодлогын баримт бичиг:

1. “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-АЛСЫН ХАРАА 2050”
2. Ардчилсан намын 2024-2028 оны сонгуулийн Мөрийн хөтөлбөр
3. “Дундговь аймгийн хөгжлийн бодлого стратеги төлөвлөгөө 2012-2031”
4. “Сумдын хөгжлийн дунд хугацааны мастер /стратеги/ төлөвлөгөөнүүд”

Эрх зүйн орчин:

- “Монгол улсын үндсэн Хууль”
- “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”
- “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”
- “Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль”
- “Сонгуулийн тухай хууль”

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд Монгол хүн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны УИХ-ын сонгуульд өргөн барьсан

“ДУНДГОВЬ ХӨГЖИНӨ” мөрийн хөтөлбөрийг Дундговь аймгийн АН өөрийн орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт үндэс болгон ажиллах бөгөөд алдагдсан 8 жилийг дүгнэсний үр дүнд алдааг засч, Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжсөн, хуулийн засаглал, шударга ёс тогтсон, хүн бүр ажил, хөдөлмөр эрхлэн, орлого нь амьдрал ахуйд хүрэлцсэн, эрүүл,

*Дундговь аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр*

аюулгүй орчинд ажиллаж, амьдарсан хүнлэг, ардчилсан нийгмийг цогцлоохыг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож, Ардчилсан намаас 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд стратегийн 9 заалтыг үндэслэн мөрийн хөтөлбөрийг өргөн барьсан байна. Иймээс энэхүү Мөрийн хөтөлбөр нь ДУНДГОВЬ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС 2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР-ийн салшгүй хэсэг болно. АН-ын 2024 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

## **НЭГ. ИРГЭД НЬ ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ДУНДГОВЬЧУУД**

- 1.1 Иргэн бүрийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
  - 1.1.1 Жил бүр аймгийн Төв эмнэлгийг хамгийн сүүлийн үеийн өндөр технологи бүхий оношилгооны 1-2 аппаратаар хангах бодлого баримталснаар ойрын хугацаанд тодорхой төрөл чиглэлийн оношилгоо, эмчилгээгээр тэргүүлэгч аймаг болно.
  - 1.1.2 Тодорхой чиглэлүүдээр эрүүл мэндийн үзлэг, оношилгоо эмчилгээгээр тэргүүлэх хэмжээнд менежмент хэрэгжүүлэх эмч боловсон хүчинг гадаад дотоодод сургах, мэрэгжилтэн солилцоо хийх, боловсон хүчин нөхцөл бололцоог бий болгоно.
  - 1.1.3 Аймгийн эмнэлэг, сувиллын газруудад гадаад дотоодын аялагчид оношлуулах, эрүүл мэндийн аялал жуулчлал хөгжих боломжийг бүрдүүлнэ.
  - 1.1.4 Сумдын эмнэлгийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг хангуулах ажлыг зохион байгуулна.
  - 1.1.5 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.
  - 1.1.6 Эх болон нярайн эндэгдлийг бууруулна
- 1.2 Уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааг улсын хэмжээнд тэргүүлэх үйл ажиллагаатай болгох талаар дэмжиж, гадаад дотоодын эмч нартай хамтран ажиллаж, эмч солилцоо, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмнэлгийн орчинг сайжруулах замаар сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлнэ.
  - 1.2.1 Эхчүүд эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуйн чиглэлээр “Эхчүүдийн сувилал”-ийг хувийн хэвшил, төрийн оролцоотойгоор байгуулахыг дэмжинэ.
  - 1.2.2 Хувийн хэвшлийн аялал жуулчлалын бааз, сумдын эмнэлгийн сул орны боломжийг хуулийн үндэслэлд тулгуурлан хүүхдийн болон ахмадын "Мэс заслын болон Эмчилгээний дараах сувилахуй, нөхөн сэргээх төрөлжсөн сувилал"-ыг байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг бүх талаар дэмжин хамтран ажиллана.
- 1.3 Аймаг, сумдын эмнэлгүүдийг алсын зайн оношилгооны техник хэрэгслээр хангаж цахим харилцаа, цахим оношилгоо хийх боломжийг бүх сумдын эмнэлгүүдэд бүрдүүлэн, гуравдахь шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэн эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь мэргэшүүлэн иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулна.
- 1.4 Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно
- 1.5 “Эрүүл өсөлт” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.6 Шинээр төрсөн ээжүүдэд “ШИНЭ ИРГЭН” төслийг хэрэгжүүлнэ.

## **2 ХОЁР. ИРГЭД НЬ ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ДУНДГОВЬЧУУД**

- 2.1 Боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх жилийн үйл ажиллагааг бүрэн эрхийн хугацаанд бүтэн хэрэгжүүлж багш, удирдах ажилтны мэргэшлийг гадаад дээшлүүлж, оюутан сурагчдыг гадаадад бэлтгэх хөтөлбөрийг

- боловсруулан хэрэгжүүлж, боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 2.2 Хүүхэд бүрт компьютер хөтөлбөрийг дэмжин ажиллана.
- 2.3 Ахмад мэрэгжилтний албыг ажиллуулах санаачилгыг дэмжин ажиллуулна.
- 2.4 Цэцэрлэг сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх, дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- 2.5 Бүх шатны багш нарыг багаар нь урамшуулах системийн улам сайжруулж боловсролын чанар хүртэмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6 Аймгийн төвд сургуулийн автобусаар үйлчилж, хүүхэд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийн бүрдүүлнэ.
- 2.7 Гадаадад болон бусад хотод суралцаж, ажиллаж байгаа болон эх орон, аймагтаа эргэн ирж байгаа залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.8 Цэцэрлэг, бага ангийн сурагчдыг "СҮҮ" хөтөлбөрт хамруулж, үдийн цайны чанар дээр анхаарч ажиллана.
- 2.9 "ХҮҮХДИЙН САН" хөтөлбөрийг боловсруулж хүүхдийн сурч боловсрох, хөгжих боломжийг хангана.
- 2.10 Хүүхдэд тулгарч буй үе тэнгийнхний дээрэлхэлт, гэр бүлийн хүчирхийлэл, бусдын дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд Гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.
- 2.11 Олон улсын жишигт нийцсэн ЕБС, дотоодын их дээд сургуулийн салбар сургууль байгуулах ажилд хувийн хэвшлийг дэмжин ажиллана.

### **ГУРАВ. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БА СОЁЛ, СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

- 3.1 Төв болон хөдөөгийн иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлтэй сууцанд амьдрах боломжийг бий болгоно.
- 3.2 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3 Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих "эрүүл, чийрэг хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.4 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- 3.5 Хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг байгуулан, СӨБ олгох үйл ажиллагаа эрхлэх иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг онцгойлон дэмжиж орчин үеийн шаардлага, олон улсын жишигт хүргэхэд хамтран ажиллана.
- 3.6 "Бүрдийн уянга" хүүхдийн зусланг "МОНГОЛ МАЛЧИН" амьдрах ухаан, ёс зан заншлын олон улсын хүүхдийн сургалтын төв болгон хөгжүүлнэ.
- 3.7 Бүх сумдын ахмадын байгууллагуудыг шаардлагатай хөгжим хэрэгслээр хангана.
- 3.8 "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын байрны асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.9 "Сүм хөх бүрд" задгай театрын үйл ажиллагааг Адаацаг сумын соёлын төвийн үйл ажиллагаатай уялдуулан сайжруулах, Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан Сүм хөх бүрдэд байгалийн түүхийн музей байгуулна.
- 3.10 Аймгийн театрын шинэ цогцолборыг бүрэн ашиглалтад оруулна.

- 3.11** “Дундговь-Дуу хуур өв соёлын орон” хөтөлбөрийг шинэчлэн сайжруулна.  
Үүнд:
- 3.11.1** Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрт шаардлагатай найруулагч, мэргэжлийн багш нарыг бэлтгэж боловсон хүчнийг чадавхижуулахад дэмжлэг үзүүлнэ.
  - 3.11.2** Их газрын чулуу байгалын үзэсгэлэнт газарт болдог 3000 уртын дууч морин хуурчдын наадмыг 2 жил тутамд зохион байгуулж соёлын аялал жуулчлалын календарьт тусган хэвшүүлнэ.
  - 3.11.3** Бүх сумдын Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, шаардлага хангасан чанартай тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.12** Аймгийн төвийн Бор овоо орчмыг амралт зугаалгын бүс болгон хөгжүүлнэ.
- 3.13** Хүүхдийн паркыг цэцэрлэгт хүрээлэн амралт зугаалгын бүс болгон өргөжүүлэн тохижуулж үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 3.14** Сум бүрт хүүхэд, залуучууд, ахмадуудад зорилсан амралт зугаалгын томоохон талбайг бий болгоно.
- 3.15** Сумдуудад хиймэл нуур байгуулах, говийг усжуулах төсөлд хамруулах ажлыг олон улсын байгууллага, улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 3.16** Задгай театр, Цагаан суварга, Онги, Сүм хөх бүрдэд улсын болон олон улсын чанартай соёл урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулна.
- 3.17** Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна
- 3.18** Түүх, соёлын хосгүй дурсгалт газар нутгуудаас улсын тусгай хамгаалалтанд оруулж хамгаалалтын бүс тогтоох ажлыг зохион байгуулж ажиллана.
- 3.19** Нийтийн биеийн тамирыг бүх шатанд хөгжүүлнэ.
- 3.20** Спортын олон төрлийн уралдаан тэмцээнийг аймагт зохион байгуулж, үндэсний болон багийн спортын клубуудыг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.

## **ДӨРӨВ. ИРГЭД НЬ АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ, АМЖИРГААТАЙ ДУНДГОВЬЧУУД**

- 4.1** 2023-2024 онд боловсруулсан зураг төслийн дагуу МАЛЧНЫ ХӨГЖЛИЙН төвийг Адаацаг сумын нутаг дэвсгэрт Сүм хөх бүрдийн байгалын үзэсгэлэнт газрыг түшиглэн байгуулснаар дараахь бодлогуудыг хэрэгжүүлнэ.Үүнд:
- 4.1.1** Малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангах бодлогоор дэмжинэ. Малчин гэр бүл хүхэн жорлонгоос татгалзаж хотондоо ариун цэвэр бохирын иж бүрдэл системийг суурилуулж усанд орох, бие засах боломж бүрдүүлэх бодлогоор дэмжинэ.
  - 4.1.2** Малчдыг өөрийг нь хөгжүүлэх замаар амьдралын түвшинг дээшлүүлж, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ авч нэг малаас авах ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх.
  - 4.1.3** Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо-техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн хөдөө орон нутагт ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх
  - 4.1.4** Малын мэдээллийн нэгдсэн сантай болно.
  - 4.1.5** Малын гоц халдварт, халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, эрсдэл бүхий бүс нутгийн малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, мал сүргийг бүрэн

вакцинжуулж, тайван тайван бүсийг бий болгох арга хэмжээг тогтмол авч ажиллана.

- 4.1.6 Мал аж ахуйн байгалийн гамшигт өртөх эрсдлийг бууруулах, зуданд зутардаггүй малчин хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, мал сүргийн тогтвортой өсөлтийг хангана.
- 4.1.7 “Дундговь-мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар мах, сүү, шувууны эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуй нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 4.1.8 Малыг олон улсын эрүүл ахуйн стандарт шаардлагын дагуу эрүүлжүүлэх бүртгэлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж мах болон малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортонд гаргах малын гаралтай бүтээгдэхүүнийг малчдын гар дээрээс хэрэглэгчдэд дамжлага багатай хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.
- 4.1.9 “МАЛЧДЫН ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ ҮНДЭСНИЙ ЖИШИГ” аймаг болгох бодлогыг хэрэгжүүлж Политехникийн коллеж-той хамтран малчны мэргэжлээр залуу малчдыг богино хугацаат сургалтуудаар бэлтгэх, улс даяар малчдын туршлага судлах, солилцох төв болгон хөгжүүлнэ.
- 4.1.10 Малыг тэжээл үйлдвэрлэж байгаа орон нутаг болон иргэдийг дэмжиж ажиллана. Дэрэн суман дахь тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, аймгийн тэжээлийн нөөцийн зохих хувийг аймагт малчид өөрөө үйлдвэрлэдэг болгох сургалтуудыг зохион байгуулдаг болгоно.
- 4.1.11 Дэрэнгийн тэжээлийн үйлдвэр болон малчдын бууц, гэр хорооллын айлууд жимс жимсгэнийн мод, жимсны аж ахуй, савлах үйлдвэрийг хөгжүүлэх, Агро парк байгуулах ажлыг хэрэгжүүлнэ
- 4.1.12 Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх зөвлөлийг Малчны хөгжлийн төвийн дэргэд байгуулж “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гарган, бэлчээр болон малын эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдтэй холбож, бодлого үйл ажиллагааны хувьд дэмжиж ажиллана. Бэлчээрийг хаших, усжуулах ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр малчид сумдын онцлогт тааруулан үе шаттайгаар зохион байгуулна
- 4.1.13 Нүүдэлчин малчдын чуулга уулзалтыг жил бүр хийж ган зудын үед отор нүүдлээр явах үед учрах эрсдлүүдээс сэргийлэх, отор нүүдлээр тусалсан малчдыг урамшуулж бахархалын арга хэмжээг хийдэг болно.
- 4.2 “Мэдээлэлжсэн нийгэм”-ийг хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ
- 4.3 Бага хүүтэй зээлийн бодлогыг дэмжиж Цагийн хөлсний системийг шаардлагатай салбаруудад нэвтрүүлэх, цалин хөлсийг ажлын үр дүнгээр тооцдог аргачлал нэвтрүүлнэ.
- 4.4 Мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг үйлдвэрийг аймгийн төв болон шаардлагатай сумдын хүчин чадалд нийцүүлэн хувийн хэвшилд тулгуурлан байгуулан ажиллуулна. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд анхаарч Чинээлэг малчин хөтөлбөрийг үржлийн, махны, сүү чиглэлийн үйл ажиллагааг эхлүүлэх.
- 4.5 “Mongol Made” төслийн хүрээнд саван гоо сайхны жижиг үйлдвэрлэлийг сум бүрт байгуулахыг дэмжиж Дундговийн брэндийг гарган сургууль цэцэрлэг зэрэг шаардлагатай байгууллагуудад хэрэглээ болгох

- 4.6 “Өвлийн нарлаг хүлэмж”-ийг төслийн хүчин чадлаар ажиллуулах, дөрвөн улирлын турш бүрэн ажиллуулж, иргэд хувийн хэвшлийн санаачилга оролцоотой хүлэмжийн төрөлжсөн үйлдвэрлэл явуулах боломжийг бүх сумдад бүрдүүлнэ.
- 4.7 “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил”-ийг дахин зарлаж, Эдийн засгийн чөлөөт бүсэд “Дундговьд бизнес инкубатор төв” байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжих ба “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.8 “Дундговьд үйлдвэрлэв” хөтөлбөрөөр аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд дэмжин хэрэглэдэг байх журам тогтоож уриалга гаргах, иргэдийг үндэсний бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
- 4.9 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- 4.10 Сумын баг бүрт орчин үеийн мал угаалгын цэгийг ОНХС, малчид, малын тоо толгойн татварыг үр ашигтай зарцуулах хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр байгуулна.

## **ТАВ. СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, БАЙГАЛ-ТҮҮХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО**

- 5.1 Гадаад хамтын ажиллагааны мэдээлэл, судалгааг бодлогоор хөгжүүлж аймаг орон нутгаа таниулах дараахь ажлуудыг хийнэ.
- 5.1.1 Торгоны зам, Цайны зам хөтөлбөрийн хүрээнд Дундговь аймгийг хамруулж хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ, худалдаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 5.1.2 Нүүдэлчдийн ахуй онцлогийг харуулсан аялал жуулчлалын “Малчин өрх” хөтөлбөрийг “Малчдын хөгжлийн төв”-д боловсруулан малчин өрхүүдээ хамруулна
- 5.1.3 Экологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар зохион байгуулж, Говийг усжуулах чийглэг уур амьсгал бүрдүүлэх Орхон, Хэрлэн төслүүдийн урт хугацааны бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд санаачилга-оролцоотой оролцоно.
- 5.1.4 Үндэсний спортыг өвлөн уламжлуулах, олон улсад сурталчлах, хөгжлийн шинэ шатанд гаргах хөтөлбөрийн хүрээнд улсын болон олон улсын шинж чанартай, аварга шалгаруулах уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулахад гаргсан амжилтуудаа бататган дэмжлэг үзүүлж ажиллана.
- 5.1.5 Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлнэ
- 5.2 Улсын чанартай хот хоорондын замын дагуух харуул хамгаалалт, тэмдэгжүүлэлт, зам засвар арчлалт хариуцах тогтолцоог хариуцлагажуулан, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах орчин үеийн шаардлага хангасан жишиг цэгүүдийг байгуулна. Энэхүү ажилд Засгийн газар, хувийн хэвшил, олон улсын төслүүдтэй хамтран ажиллана.
- 5.3 “Сүм хөх бүрд” түүх дурсгалт цогцолбор, байгалын баян бүрдийг нөхөн сэргээж аялал жуулчлалын цогцолбор болгож өргөжүүлэн Соёлын өвийг хамгаалах сэргээн засварлах ажлыг бүрэн хийлгэнэ.
- 5.4 “Их газрын чулуу”, “Бага газрын чулуу”, “Цагаан суварга”, Онгийн хийд зэрэг аялал жуулчлалын баазуудыг олон улсын аялал, жуулчлалын бүстэй холбох ажлыг зохион байгуулна.

- 5.5 2023 онд аймгийн ИТХ-аар баталсан “Дэл Хөнжил”-ийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Цагаан суварга-Үл-олдохын талыг холбосон байгал-спорт аялалын өвөрмөц маршрутыг бие даасан “Монгол говь” олон улсын аялалын маршрут болгон хөгжүүлэх, “Онгийн хийд” орчмын хүмүүсийн эдийн болон оюуны үнэт дурсгалууд бүхий газар нутгийг хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх бодлогуудыг хэрэгжүүлнэ.

**ЗУРГАА. ИРГЭД НЬ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЗАСАГЛАЛ НЬ АРДЧИЛСАН ДУНДГОВЬЧУУД**

- 6.1 Хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчдийн ниймгийн баталгааг ханган ажиллана.
- 6.2 Бүх сумдын газар нутгийн хил хязгаарыг шинэчлэн баталгаажуулах ажлыг УИХ, Засгийн газартай хамтран хэрэгжүүлж газар нутгийн маргаантай байдлыг арилгах нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- 6.3 Хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд татварын хувь хэмжээг хамгийн бага хэмжээнд барьж, нэмэгдүүлэхгүй байх бодлого барьж ажиллана
- 6.4 “Шинэ Мандалговь” шинэ суурьшлын бүсийг байгуулах эхлэлийг тавьж, Дундговь аймгаа хүнжүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх бодлого зорилтыг дэвшүүлж ажиллана.
- 6.5 Аймаг сумыг өөрийн дүрэмтэй болгож ажиллуулна.
- 6.6 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, шилэн болгоно. Худалдан авах ажиллагааг тодорхой зарлах, шалгаруулалтыг хуульд нийцүүлэн олон нийтэд ил тодоор хүргэж байна.
- 6.7 Аймаг, сумдын удирдлага үйл ажиллагааны тайлангаа иргэдэд нээлттэй тайлагнадаг механизмыг бүрдүүлнэ.
- 6.8 “Орон нутгийн хөгжлийн сан”-д иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.9 Гадаадад ажиллаж, амьдарч байгаа Дундговийнхоо иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний сурч мэдсэн зүйлийг аймагтаа хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

**ДОЛОО. ОРЧИН НЬ АМАР ТАЙВАН АЮУЛГҮЙ ДУНДГОВЬ АЙМАГ**

- 7.1 Хууль бус уул уурхайн эсрэг иргэдийн дуу хоолой болж ажиллана.
- 7.2 Бичил болон уул уурхайн бизнес эрхлэгчдийн байгаль орчинд халгүй, аюулгүй технологи нэвтрүүлэн ажиллуулахыг шаардан ажиллана.
- 7.3 Экологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар зохион байгуулж, чийглэг уур амьсгал бүрдүүлэх урт хугацааны бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд санаачилгатай оролцоно.
- 7.4 Ган зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоог шинэчлэн бий болгож, бэлэн байдлын нөөцийн хэмжээг тогтооно. Газар хөдлөлт болон бусад гамшгийн мэдээлэл, судалгааны газрын хүчин чадал, техник технологийг шинэчлэнэ.
- 7.5 Ундны ус цэвэршүүлэх, бохир ус цэвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлнэ. Аймгийн төвд үйлчилгээний газруудад иргэдэд шүүлттэй цэвэршүүлсэн ус хэрэглэх стандартыг тогтоож шаардан ажиллана.
- 7.6 Аймаг, сумын төвийн утаа, тоосонцор тоосжилтын эх үүсвэрийн судалгааг гаргаж, зэрэглэлийн бүс тогтоож, хязгаарлалтын арга хэмжээ авна.
- 7.7 Мандалговь хотыг хэрэглээний усаар хангах ус цэвэршүүлэх байгууламжийг батлагдсан зураг, төсвийн дагуу байгуулна.
- 7.8 “ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, мод, жимс жимсгэний мод суулгац үржүүлгийн аргопарк байгуулна.

- 7.9 Жил бүр 10 /га/-аас доошгүй талбайд ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулна.
- 7.10 Аймаг сумын хэмжээнд агаарын бохирдолгүй болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 7.11 Аймаг, бүх сумын төвүүд явган хүнд зориулагдсан, чөлөөт цаг-худалдаа үйлчилгээний “Авто машингүй гудамж”-тай болно.
- 7.12 Гэрээт болон орон нутаг дахь цэргийн албан хаагчдыг орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулна.
- 7.13 Орон нутагт байрлах тусгай чиг үүргийн байгууллагын ажилтан албан хаагчдын амьдрах орчинг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд дэмжиж ажиллана.
- 7.14 Камержуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж, төв цэгээс нэгдсэн байдлаар хянадаг болох боломжийг бүрдүүлнэ.
- 7.15 Сум болон хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг сайжруулна.

**НАЙМ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ДУНДГОВЬ АЙМАГТ**

- 8.1 Иргэдийн оролцоотой "Шинэ сум" хөтөлбөрийг 2020-2024 онд шинэчлэн батлуулсан сумын Ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр 15 сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн суурин болгон хөгжүүлнэ.
- 8.2 Бүх сумын төвүүдийг цэвэр устай холбож байгууллага, гэр хорооллыг нүхэн жорлонгүй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 8.3 Уул уурхайн ил тод байдлыг хангах зорилгоор төр хувийн хэвшил, иргэний гурван талт хэлэлцүүлэг, чуулганыг хийж хэвшүүлнэ.
- 8.4 Аймгийн хэмжээнд “эрчим хүч экспорлогч” зорилтыг дэмжин сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 8.5 Аймгийн төвийг Хотын статусын дагуу хөгжүүлж Сайнцагаан сумын гэр хорооллын замыг хатуу хучилттай болгож, гэрэлтүүлгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 8.6 Аймгийн газар нутгийг үүрэн телефон болон интернетээр хамруулах шилжилтэд 90-ээс доошгүй хувь хамруулж Малчид гэрээсээ интернет ашиглах боломжтой болно.
- 8.7 "Орон сууцжуулах" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Түрээсийн орон сууцны хөтөлбөрт аймгийнхаа иргэд, залуу гэр бүл, төрийн албан хаагчдыг үе шаттайгаар хамруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 8.8 Мандалговь хотод Дулааны станц ашиглалтад ороход магистрал шугамуудыг холбох ажлын бэлтгэлийг хангаж, гэр хорооллыг цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлын бэлтгэл ажлыг хангана.
- 8.9 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууц, байшин барилгуудыг буулгаж, шинээр барих төсөл хэрэгжүүлнэ.
- 8.10 Шаардлагатай сумдын сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төв, спорт заалын барилгуудыг барина.
- 8.11 Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замыг шинэчлэн өргөтгөж, Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замыг шинээр барих ажлын хэрэгжилтийг шаардан зам дагуух үйлчилгээний бизнес хөгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.

- 8.12 Чойр-Мандалговь-Арвайхээрийн замыг түшиглэн аймгаар дамжин өнгөрөх тээврийн урсгал, бизнес боломжийг Дундговь-Ложистик төв болгох хөтөлбөрийг боловсруулна.
- 8.13 Төв зам дагуу иж бүрэн усалгааны систем бүхий мод тарих хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 8.14 Усан бассейн бүхий спорт цогцолборын үйл ажиллагааг эхлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 8.15 Төрийн нэг цэгийн үйлчилгээний төвийн барилга /Сайнцагаан сум/-ыг ашиглалтад оруулах
- 8.16 Дэрэн сумын ариун цэвэр ус, бохир усны татуургын байгууламжийг ашиглалтад оруулна.
- 8.17 Бүх сумдын нутгийн удирдлагын ордонг шаардлага хангасан бие засах газартай болгож иргэдийн төрийн үйлчилгээ авахад ая тухтай орчинг бүрдүүлэхийг шаардан ажиллана.
- 8.18 Ахмадын өргөөний барилга /Гурвансайхан, Өлзийт/ ашиглалтанд оруулах
- 8.19 Сургуулийн барилга /Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор, Эрдэнэдалай, Дэрэн / ашиглалтанд оруулах
- 8.20 Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Эрдэнэдалай сум, 2 дугаар цэцэрлэг/ ашиглалтанд оруулах
- 8.21 Соёлын төвийн барилга / Цагаандэлгэр, Өндөршил, Баянжаргалан, Дэлгэрхангай / ашиглалтанд оруулах
- 8.22 Эрүүл мэндийн төвийн барилга /Дундговь, Дэрэн сум/ ашиглалтанд оруулах
- 8.23 Нутгийн удирдлагын ордон / Дэрэн / ашиглалтанд оруулах
- 8.24 Спорт заалны барилга /Луус сум/ ашиглалтанд оруулах
- 8.25 Шаардлагатай сумдад төрийн албан хаагчдын орон сууцжуулах

**ДУНДГОВЬ НУТАГ МИНЬ ҮҮРД МАНДАН БАДРАГ !**

Мөрийн хөтөлбөр бэлтгэсэн: *Ардчилсан намын Дундговь аймгийн хороо-г төлөөлж*

*Нам /эвсэл/-ын нэр*

(тэмдэг) *Дундговь аймгийн Ардчилсан намын дэд дарга*  
— *ыг төлөөлж*

*Овог нэр / Номхондорж Мэндсайхан/*



*2024 оны 06 дугаар сарын 22-ны 16:00 цаг*  
*Мандалговь хот*



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ  
СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ХОРООНД**

2024-07-09 № 01/134  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Адаацаг сумын “Ардчилсан нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Адаацаг сумын “Ардчилсан нам”-ын хорооны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (7 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Адаацаг сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ...../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР ...../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР ...../Т.БАТСАЙХАН/

АХЛАХ АУДИТОР ...../Ч.БЭРХСАЙХАН/



Адаацаг сумын Ардчилсан Намын Хорооны  
2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн  
хурлаар хэлэлцэж батлав.



АДААЦАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

---

## НЭГ. ИРГЭН БҮР ЭРҮҮЛ СУМ

- 1.1 Иргэн бүрийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.2 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.
- 1.3 Эх болон нярайн эндэгдлийг бууруулна
- 1.4 Эко сумын төв болгох зорилт тавин ажиллана
- 1.5 Эхчүүд эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуйн чиглэлээр "Эхчүүдийн сувилал"-ийг хувийн хэвшил, төрийн оролцоотойгоор байгуулна.
- 1.6 Эмнэлгийн сул орны боломжид тулгуурлан хүүхдийн болон ахмадын "Эмчилгээний дараах сувилахуйн болон нөхөн сэргээх төрөлжсөн сувилал"-ыг байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг бүх талаар дэмжин хамтран ажиллана.
- 1.7 Эмнэлгүүдийг алсын зайн оношилгооны техник хэрэгслээр хангаж цахим харилцаа, цахим оношилгоо хийх боломжийг бүрдүүлж 3-р шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь мэргэшүүлэн иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулна.
- 1.8 Тэмбүү, бэлгийн замын халдварт өвчингүй сум болох зорилт тавин ажиллана
- 1.9 "Эрүүл өсөлт" хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.10 Шинээр төрсөн ээжүүдэд "ШИНЭ ИРГЭН" төслийг хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ИРГЭД НЬ ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ СУМ

- 2.1 Багш, удирдах ажилтны мэргэшлийг дээшлүүлж, боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 2.2 Бүх шатны багш нарыг багаар нь урамшуулах системийн улам сайжруулж боловсролын чанар хүртэмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3 Цэцэрлэг, бага ангийн сурагчдыг "СҮҮ" хөтөлбөрт хамруулж, үдийн цайны чанар дээр анхаарч ажиллана.
- 2.4 "ХҮҮХДИЙН САН" хөтөлбөрийг боловсруулж хүүхдийн сурч боловсрох, хөгжих боломжийг хангана.
- 2.5 Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.

**ГУРАВ. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БА СОЁЛ, СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

- 3.1 Төв болон хөдөөгийн иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлтэй сууцанд амьдрах боломжийг бий болгоно.
- 3.2 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3 Иргэдийн хуримтлал үүсгэх дадлыг бий болгохын тулд "Хүртээмжтэй хуваарилалт- Хуримтлалтай иргэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 3.4 Хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг байгуулан, СӨБ олгох үйл ажиллагаа эрхлэх иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг онцгойлон дэмжиж орчин үеийн шаардлага, олон улсын жишигт хүргэхэд хамтран ажиллана.
- 3.5 "Ахмадын байгууллагууд"-ын үйл ажиллагааг дэмжиж санхүүжүүлэх тогтолцоог бий болгож, шаардлагатай хөгжмийн хэрэгсэлээр хангана
- 3.6 Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, шаардлага хангасан чанартай тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.7 Хүүхэд, залуучууд, ахмадуудад зориулсан амралт зугаалгын томоохон талбайг бий болгоно.
- 3.8 Хиймэл нуур байгуулах, говийг усжуулах төсөлд хамруулах ажлыг олон улсын байгууллага, улсын төсөв, хувийн хэвшил зэргээс хөрөнгө оруулалтыг бүрдүүлж ажиллана.
- 3.9 Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна
- 3.10 Түүх, соёлын хосгүй дурсгалт газар нутгаа улсын тусгай хамгаалалтанд оруулж хамгаалалтын бүс тогтооно.
- 3.11 Нийтийн биеийн тамирыг бүх шатанд хөгжүүлнэ.
- 3.12 Спортын клубуудыг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- 3.13 Үндэсний болон багийн спорт клубуудыг дэмжих бодлого баримтална.

**ДӨРӨВ. ИРГЭД НЬ АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ, АМЖИРГААТАЙ СУМ**

- 4.1 Цагийн хөлсний системийг шаардлагатай салбаруудад нэвтрүүлнэ.
- 4.2 Малын мэдээллийн нэгдсэн сантай болно.
- 4.3 Мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг үйлдвэрийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулан ажиллуулна.
- 4.4 Иргэд хувийн хэвшлийн санаачилга оролцоотой хүлэмжийн төрөлжсөн үйлдвэрлэл явуулах боломжийг бүрдүүлнэ.

4.5 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо-техникчдийг тэтгэлэгт хөтөлбөрөөр бэлтгэн, хөдөө орон нутагт ажиллуулна.

4.6 “Бизнес эрхлэгчдийг” дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.7 Мах, сүү, шувууны эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуй нэгжийг бодлогоор дэмжинэ.

4.8 Орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд гаргах нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг байгуулахыг дэмжинэ.

4.9 Малыг гоц халдварт, халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, эрсдэл бүхий бүс нутгийн малыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, мал сүргийг бүрэн вакцинжуулж, тайван тайван бүсийг бий болгоох арга хэмжээг тогтмол авч ажиллана.

4.10 “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

4.11 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийг өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлнэ.

4.12 Мал аж ахуйн байгалийн гамшигт өртөх эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх, мал сүргийн тогтвортой өсөлтийг хангана.

4.13 Баг бүрт мал угаах “ванн” бүхий шаардлагатай орчин үеийн угаалгын цэгийг ОНХС, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр байгуулна.

4.14 Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх зөвлөл байгуулж “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гарган, бэлчээр болон малын эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрүүдтэй холбож, бодлого үйл ажиллагааны хувьд дэмжиж ажиллана. Бэлчээрийг усжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.15 Малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ. Малчин гэр бүл хотондоо ариун цэвэр бохирын системийг бүрэн суурилуулж гэртээ усанд орж, бие засах боломжийг бүрдүүлнэ

## **ТАВ.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО**

5.1 Сум орон нутгаа гадаадын улс орнуудад таниулан хамтран ажиллах шинэ гарцуудыг бий болгоно. Гадаадын хамтын ажиллагааны мэдээлэл, судалгааны төв байгуулж аймаг орон нутгаа таниулах ажлыг хийнэ.

5.2 Нүүдэлчдийн ахуй онцлогийг харуулсан аялал жуулчлалын “Малчин” хөтөлбөрийг боловсруулан малчин өрхүүдээ хамруулна

5.3 Экологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар зохион байгуулж, чийглэг уур амьсгал бүрдүүлэх урт хугацааны бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд санаачилгатай оролцоно.

5.4 Үндэсний спортыг өвлөн уламжлуулах, олон улсад сурталчлах, хөгжлийн шинэ шатанд гаргах хөтөлбөрт дэмжлэг үзүүлнэ.

5.5 Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлнэ

## **ЗУРГАА. ИРГЭД НЬ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЗАСАГЛАЛ НЬ АРДЧИЛСАН ДУНДГОВЬЧУУД**

6.1 Төрийн албан хаагчийг ажлаас халах, ажлын байрны хөдөлгөөн хийхийг хязгаарлана.

6.2 Хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчдийн ниймгийн баталгаа хангана.

6.3 Сумдын газар нутгийн хил хязгаарыг шинэчлэн баталгаажуулах ажлыг УИХ, Засгийн газартай хамтран хэрэгжүүлж газар нутгийн маргаантай байдлыг арилгах нөхцлийг бүрдүүлж ажиллана.

6.4 Хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд татварын хувь хэмжээг хамгийн бага хэмжээнд барьж, нэмэгдүүлэхгүй байх бодлого барьж ажиллана

6.5 Ил тод, нээлттэй, хүнд сурталгүй, шуурхай төрийн ЦАХИМ үйлчилгээг нэвтрүүлнэ.

6.6 Удирдлагын хариуцлагыг тооцох цогц арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлнэ.

6.7 Орон нутгийн хөгжлийн сангийн 3-5 хувийг Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн бодитой үр дүнд хүрэхүйц гэрээг хэрэгжүүлэхэд зарцуулдаг болгоно.

6.8 Сум орон нутгийнхаа эв нэгдэл, эрх ашгийн үүднээс улс төрийн нам, төрийн бус байгууллагатай бүхий л талаар хамтран, тэдний санал санаачилгыг дэмжиж ажиллана. Улс төрийн нам эвсэл, төрийн бус байгууллагатай орон нутгийн сайн сайхны төлөө хамтарч ажиллана.

6.9 Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, шилэн болгоно. Худалдан авах ажиллагааг тодорхой зарлах, шалгаруулалтыг хуульд нийцүүлэн, шалгаруулалтын үйл ажиллагааг ямар шалгуураар хэрхэн дүгнэж байгааг олон нийтэд ил тодоор хүргэж байна.

6.10 Сумын удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайлангаа иргэдэд нээлттэй тайлагнадаг механизмыг бүрдүүлнэ.

6.11 “Орон нутгийн хөгжлийн сан”-д иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

## **ДОЛОО. ОРЧИН НЬ АМАР ТАЙВАН АЮУЛГҮЙ ДУНДГОВЬ АЙМАГ**

7.1 Экологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар зохион байгуулж, чийглэг уур амьсгал бүрдүүлэх урт хугацааны бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэхэд санаачилгатай оролцоно.

7.2 Ган зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоог шинэчлэн бий болгож, бэлэн байдлын нөөцийн хэмжээг тогтооно. Газар хөдлөлт болон бусад гамшгийн мэдээлэл, судалгааны газрын хүчин чадал, техник технологийг шинэчлэнэ.

7.3 Ундны ус цэвэршүүлэх, бохир ус цэвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.

7.4 Сумын төвийн хог ангилан ялгах, дахин боловсруулах, булшлах шинэлэг арга технологийг нэвтрүүлнэ.

7.5 Сумын төвийн утаа, тоосонцор тоосжилтын эх үүсвэрийн судалгааг гаргаж, зэрэглэлийн бүс тогтоож, хязгаарлалтын арга хэмжээ авна.

7.6 “ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана

7.7 жил бүр 3,0 мянгаас доошгүй мод, будыг шинээр тарьж ургуулна.

7.8 Камержуулах үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж, төв цэгээс нэгдсэн байдлаар хянадаг болох боломжийг бүрдүүлнэ.

7.9 Сум болон хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг сайжруулна.

**НАЙМ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

8.1 Иргэдийн оролцоотой "Шинэ сум" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн суурин болгон хөгжүүлнэ. Сумын төвийн шинэчлэлийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

8.3 Соёлын төвийн барилгыг шинээр барихад хамтарч бүх талаар дэмжиж ажиллана

8.4 Багийн төвүүдийг 4-5G рүү шилжих шилжилтэд хамруулж Дундговийн хэмжээнд үүрэн телефон барих боломжтой болгоно. Малчид гэрээсээ интернет ашиглах боломжтой болно

**АДААЦАГ НУТАГ МИНЬ ҮҮРД МАНДАН БАДРАГ**

Мөрийн хөтөлбөр бэлтгэсэн: *Ардчилсан намын Дундговь аймгийн Адаацаг сумын хороо-г төлөөлж*

*Нам /эвсэл/-ын нэр*

(тэмдэг) *Дундговь аймгийн Адаацаг сумын Ардчилсан намын дарга*  
\_\_\_\_\_ -ыг төлөөлж

гарын үсэг



Дундговь аймгийн Адаацаг сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр

Овог нэр /Чимэддоржийн Уранчимэг/

2024 оны 06 дугаар сарын 22-ны 16:00 цаг



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сүм  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД**

2024-04-09 № 01/142

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Баянжаргалан сумын “Ардчилсан нам”-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2024 оны төсөв, 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Баянжаргалан сумын “Ардчилсан нам”-ын хорооны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого,

төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянжаргалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (7 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн Баянжаргалан сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ...../Р.МӨНХТОГТОХ/

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР ...../Т.ОЮУН-ЭРДЭНЭ/

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР ...../Т.БАТСАЙХАН/

АХЛАХ АУДИТОР ...../Ч.БЭРХСАЙХАН/



Баянжаргалан сумын Ардчилсан Намын Хорооны  
2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн  
хурлаар хэлэлцэж батлав.



БАЯНЖАРГАЛАН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

---

## **НЭГ. ИРГЭН БҮР ЭРҮҮЛ СУМ**

- 1.1 Иргэн бүрийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.
- 1.2 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.
- 1.3 Эх болон нярайн эндэгдлийг бууруулна
- 1.4 Эко сумын төв болгох зорилт тавин ажиллана
- 1.5 Эхчүүд эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуйн чиглэлээр “Эхчүүдийн сувилал”-ийг хувийн хэвшил, төрийн оролцоотойгоор байгуулна.
- 1.6 Эмнэлгийн сул орны боломжид тулгуурлан хүүхдийн болон ахмадын “Эмчилгээний дараах сувилахуйн болон нөхөн сэргээх төрөлжсөн сувилал”-ыг байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг бүх талаар дэмжин хамтран ажиллана.
- 1.7 Эмнэлгүүдийг алсын зайн оношилгооны техник хэрэгслээр хангаж цахим харилцаа, цахим оношилгоо хийх боломжийг бүрдүүлж 3-р шатлалын эмнэлгүүдтэй хамтран ажиллаж, оношилгоо эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр нь мэргэшүүлэн иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулна.
- 1.8 Тэмбүү, бэлгийн замын халдварт өвчингүй сум болох зорилт тавин ажиллана
- 1.9 “Эрүүл өсөлт” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн өвчлөлийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдлээс бага насанд нь сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.10 Шинээр төрсөн ээжүүдэд “ШИНЭ ИРГЭН” төслийг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ИРГЭД НЬ ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ СУМ**

- 2.1 Багш, удирдах ажилтны мэргэшлийг дээшлүүлж, боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 2.2 Бүх шатны багш нарыг багаар нь урамшуулах системийн улам сайжруулж боловсролын чанар хүртэмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3 Цэцэрлэг, бага ангийн сурагчдыг “СҮҮ” хөтөлбөрт хамруулж, үдийн цайны чанар дээр анхаарч ажиллана.
- 2.4 “ХҮҮХДИЙН САН” хөтөлбөрийг боловсруулж хүүхдийн сурч боловсрох, хөгжих боломжийг хангана.
- 2.5 Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД БА СОЁЛ, СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

- 3.1 Төв болон хөдөөгийн иргэдийг зээлийн хөнгөлөлттэй нөхцөлтэй сууцанд амьдрах боломжийг бий болгоно.
- 3.2 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3 Иргэдийн хуримтлал үүсгэх дадлыг бий болгохын тулд "Хүртээмжтэй хуваарилалт- Хуримтлалтай иргэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ
- 3.4 Хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэг байгуулан, СӨБ олгох үйл ажиллагаа эрхлэх иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг онцгойлон дэмжиж орчин үеийн шаардлага, олон улсын жишигт хүргэхэд хамтран ажиллана.
- 3.5 "Ахмадын байгууллагууд"-ын үйл ажиллагааг дэмжиж санхүүжүүлэх тогтолцоог бий болгож, шаардлагатай хөгжмийн хэрэгсэлээр хангана
- 3.6 Соёлын төвийг стандартад нийцүүлэн хөгжүүлэх бодлого баримталж, шаардлага хангасан чанартай тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.7 Хүүхэд, залуучууд, ахмадуудад зориулсан амралт зугаалгын томоохон талбайг бий болгоно.
- 3.8 Хиймэл нуур байгуулах, говийг усжуулах төсөлд хамруулах ажлыг олон улсын байгууллага, улсын төсөв, хувийн хэвшил зэргээс хөрөнгө оруулалтыг бүрдүүлж ажиллана.
- 3.9 Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна
- 3.10 Түүх, соёлын хосгүй дурсгалт газар нутгаа улсын тусгай хамгаалалтанд оруулж хамгаалалтын бүс тогтооно.
- 3.11 Нийтийн биеийн тамирыг бүх шатанд хөгжүүлнэ.
- 3.12 Спортын клубуудыг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- 3.13 Үндэсний болон багийн спорт клубуудыг дэмжих бодлого баримтална.

